



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №34



2018 оны 10-р сарын 01-05

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1218** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 106(8.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1084(88.9%) хачигт халдвар, 12(1.0%) бэтэг, 2(0.2%) хумхаа, 8(0.7%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1084** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.4%-иар бага байна. Эпидемиологийн 40-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



Хачигт риккетсиозын 804 сэжигтэй тохиолдлын 199(24.7%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна.


1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **106** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15%-иар бага байна. Эпидемиологийн 40-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



1.4 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 93 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 13.3%-иар их байна. Эпидемиологийн 40-р долоо хоногтой харьцуулахад 2 дуудлагаар илүү байна.



Энэ 7 хоногт СХД, ХУД-ээс ирүүлсэн 4 удаагийн амьтны (тарвага 8 ширхэг) дуудлагад үйлчилж, хураагдсан сорьцыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Өвчлөл бүртгэгдээгүй байна.

Олон улсад:

Баруун нилийн халуурал:


Словения улсын Лжублжана хотын аж ахуйд баруун нилийн халуурал өвчин бүртгэгдэж, 12 адуу өртөмхий байснаас, 1 адуу өвчилж, 1 адууг устгаж тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллажээ.

Эх сурвалж: ДАЭМБ

Эбола вирус халдвар:

Бүгд найрамдах ардчилсан Конго (БНАК) улсад 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Kalunguta, Masereka, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 151 сэжигтэй (120 батлагдсан, 31 болзошгүй) тохиолдол, үүнээс 101 нас баралт мэдээлэгдсэн байна. Нийт тохиолдлын

56%-ийг эмэгтэйчүүд эзлэж байна. Одоогоор БНАК улсад 201 хүний бүрэдэхүүнтэй баг дэгдэлтийн голомтонд ажиллаж байна.



Эх сурвалж: ДЭМБ


Африкийн гахайн мялзан өвчин:

Румын улсын Тулсиа хотын Энисала мужид Африкийн гахайн мялзан өвчний улмаас 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Гахайн сонгомол малзан өвчин:

Япон улсын Гифү хотын Гифү мужийн ойд Гахайн сонгомол мялзан өвчний улмаас 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна. Тус мужид халдваргүйтгэлийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:


Колумби улсын Согатосо мужид “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдэж, 18 үхэр өртсөнөөс, 1 үхэр өвчилсөн. Тус мужид хорио цээрийн дэглэм тогтоосон байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу:


ОХУ-ын Ростовская мужийн Каменский бүс нутагт 9 дүгээр сарын 24-нд шувууны томуугийн өвчлөл бүртгэгдсэн байна. Нийт 274929 шувуу өртөмхий байснаас 11979 шувуу өвчилж үхсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Болгар улсын Трилистник, Пловдив бүс нутагт шувууны томуугийн тохиолдол бүртгэгдэж 44063 шувуу өртөмхий байснаас 415 шувуу өвчилж үхсэн, 43648 шувууг устган халдваргүйтгэл хийсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Жич: Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Баганнуур, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?